Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА ЛХАГВАСҮРЭНГИЙН НЯМДОРЖИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилт:** Харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын технологи, дэвшилтэт технологи, инновац, цахим засаглалын бодлого, стратегийг төлөвлөх, салбарын хөгжлийн бодлого, стандарт, төсөл хөтөлбөрийн хувилбар боловсруулах, салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; | | | | | | | | |
| **Зорилт 1. Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх** | | | | | | | | |
| 1.1 | “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тус яамнаас боловсруулахаар туссан хууль тогтоомжийн төслийг хариуцсан албан хаагчидтай | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Боловсруулсан хуулийн төслийн тоо | 0 | 0 | 6 | Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тус яамнаас хариуцан боловсруулах 5 хуулийн төслийн хэрэгжилтэд хариуцсан албан хаагчидтай хамтран ажиллаж байна:<br>1.Дэлхийн шуудан холбооны дүрмийн арваннэгдүгээр нэмэлт протоколыг соёрхон батлуулах талаар Засгийн газраас ирүүлсэн санал, дүгнэлтийн дагуу үзэл баримтлалыг дахин батлуулах ажил хийгдэж байна. | 20% |

104

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран боловсруулах | | | | | | 2.Шуудангийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт 2024 онд хийсэн үнэлгээгээр уг хуулийг шинэчлэн найруулах практик хэрэгцээ, шаардлага үүссэн гэж дүгнэсэн бөгөөд хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг төрийн болон хувийн хэвшлийн, холбогдох мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдүүлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/152 дугаар тушаалаар байгуулаад байна.<br>3.Харилцаа холбооны тухай болон Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг 2024 оны 11 сард Сайдын орон тооны бус зөвлөхөөр ахлуулан байгуулсан ч яамны зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан Ажлын хэсгээс шийдвэр гараагүй байна. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулж дууссан.<br>4.Дроны ашиглалт, угсралтын талаарх эрх зүйн орчны судалгааг хийх, дрон такси үйлчилгээ нэвтрүүлэх санал боловсруулах Ажлын хэсгийг төрийн болон хувийн хэвшлийн, холбогдох мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдүүлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар байгуулан ажиллуулсан.<br>Яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн “Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ | |

105

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах ажлын даалгаврыг батлуулсан. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/98 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо уг тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 21 болон 05 дугаар сарын 29-ний өдрүүдэд тус тус зарласан боловч амжилтгүй болж, мөн төсвийн тодотголоор төсөв хасагдсан тул судалгааны ажил зогсоод байна. | |
| 1.2 | Хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актыг холбогдох албан хаагчидтай хамтран боловсруулах | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Арга зүйн зөвлөгөө үзүүлж хамтран ажилласан журмын тоо | 59 | 0 | 15 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар сайдаас 15 хуульд захиргааны хэм хэмжээний акт батлах 42 эрх олгосон заалт туссанаас 32 заалтын хүрээнд, Засгийн газраас 9 хуульд захиргааны хэм хэмжээний акт батлах 36 эрх олгосон заалтын хүрээнд 38 акт батлахаар туссанаас 29 актыг тус тус боловсруулж, баталсан байна.<br>Тайлант хугацаанд дор дурдсан захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулахад холбогдох албан хаагчидтай хамтран ажилласан:<br>1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх виртуал бүсийн ажиллах журам;<br>2.Виртуал бүсийн ажиллах журам;<br>3.Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам;<br>4.Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам;<br>5.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам; | 80% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 6.Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам;<br>7.Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам;<br>8.Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам;<br>9.Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам;<br>11. Аж ахуйн нэгжийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хэрэгжүүлсэн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага;<br>12.Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт. | |
| 1.3 | Сайдын шийдвэрээр батлуулсан захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн санд бүртгүүлэх зохион байгуулалтыг хийх | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Бүртгүүлэхээр хүргүүлсэн хэм хэмжээний актын тоо | 3 | 2 | 2 | Тайлант хугацаанд дор дурдсан захиргааны хэм хэмжээний актыг боловсруулан батлсныг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хугацаанд багтаан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлийг хийлгэсэн:<br>1.Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам;<br>2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлагад | 100% |

104

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам;<br>4.Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт;<br>5.Аж ахуйн нэгжийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хэрэгжүүлсэн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага. | |
| 1.4 | Захиргааны хэм хэмжээний актын салбарын нэгдсэн бүртгэл хөтлөх цахим системийг бий болгох | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Системтэй болсон байх | - | 1 | | Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлсэн шийдвэрүүдээр салбарын сан байгуулж, иргэдийг мэдээллээр хангах ажлыг хариуцан ажиллаж байна. Салбарын санг цахим хэлбэрт шилжүүлэх талаар системийн ажлын даалгаврыг боловсруулж, И-Монгол академи УТҮГ-аар 2026 оны төлөвлөгөөнд тусгуулсан хийлгэхээр төлөвлөөд байна. | 10% |
| 1.5 | Захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, журмаар зохицуулах харилцааг холбогдох хуульд тусгах асуудлаар салбарт хамаарах Засгийн газрын тогтоолоор баталсан хэм хэмжээний актад | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн актын тоо | 0 | 26 | | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар нийт 15 хуульд захиргааны хэм хэмжээний акт батлах 78 эрх олгосон заалт туссанаас 61 акт батлагдсан. Эдгээр актуудад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр Шуудангийн тухай, Радио долгионы тухай, Өргөн нэвтрүүлгийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулаад байна. Хуулийн төсөл батлагдсанаар 6 хуулийн хүрээнд эрх олгосон 7 журмын зохицуулалт хуульд тусаж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | | | | | журам батлах эрх олгосон 9 заалт хүчингүй болох ба дээрх хуулийн төслийг "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д туссан хуулийн төслүүдтэй хамтатган боловсруулахаар төлөвлөөд байна. | |
| 1.6 | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шийдвэртэй холбогдох эрх зүйн маргааныг хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын эрх ашгийг хамгаалан оролцох | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон хэргийн тоо | 4 | 1 | 1.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан "Радио долгионы ашиглалт үйлчилгээний төлбөр тогтоох журам"-ын 2.2.8 дахь заалтыг хүчингүй болгуулах тухай Ондо ХХК-ын нэхэмжлэлтэй захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд шинжээч С.Ончимэгийн хамт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан бөгөөд тус компани гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсаныг шүүх баталгаажуулж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргасан.<br>2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2025 онд хэрэгжүүлж байгаа "Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээний багц 11-ийн гүйцэтгэгчээр шалгарсан Дүйнхэр тэргүүн ХХК-ийн нэхэмжлэлтэй гэрээ байгуулахыг даалгах нэхэмжлэлийн хүрээнд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 128/ШШ2025/0415 дугаартай шийдвэрийг бүхэлд нь эс зөвшөөрч манай талаас Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдөр гомдол гаргасныг 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хянан хэлэлцэх шүүх хуралдаанд оролцсон бөгөөд шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хүчингүй болгосон. | 100% |

109

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Энэ шийдвэрийг нэхэмжлэгчээс хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хяналтын шатны шүүхэд гомдол гаргасныг Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээс татгалзаж шийдвэрлэсэн болно.<br>3.Бүтцийн өөрчлөлтийн улмаас албан тушаалын орон тоо хасагдаж, ажлаас чөлөөлөгдсөн Б.Уранзаяа, Б.Урангоо нараас Захиргааны хэргийн анхан шатны гүүхэд ажилд эргүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин, олговрыг нөхөн гаргуулах нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ТЗУГ-ын ахлах шинжээч Г.Өнөрхуяг, ахлах мэргэжилтэн Э.Анхбаяр нарын хамт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан. Анхан шатны шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 128/ШШ2025/0597, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 128/ШШ2025/0621 дугаартай шийдвэр гаргаж нэхэмжлэлийг тус тус хангаж шийдвэрлэсэн. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу анхан шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргаагүй болно. | |
| 1.7 | Нэгжид удирдлагаас шилжүүлсэн хууль, журмын төсөлд санал боловсруулж, хүргүүлэх | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Хууль тогтоомжид салбарын асуудлыг тусгах талаарх саналыг тухай бүрд хуулийн хугацаанд | Хуулийн төсөл, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоолын | Салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулахад холбогдох талуудаас санал авч, нэгтгэн хүргүүлэх зохион байгуулалтыг хийсэн байна. | Тайлант хугацаанд 285 албан бичиг удирдлагаас цохолттой ирснээс шийдвэрлэсэн 258, судлагдаж байгаа 2 албан бичиг байна. Үүнээс 209 албан бичгийн дагуу ирүүлсэн хууль, журам, тогтоолын төсөлд Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайдын саналыг хүргүүлсэн. | 100% |



110

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох байгууллагад хүргүүлсэн байх | төсөл, сайдын тушаалд санал авахаар ирүүлсэн 288 албан бичгийг судалж, саналыг тухай бүрд хүргүүлсэн | | | |
| 1.8. | Яамны дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх журмын төсөл боловсруулах | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Боловсруулсан журмын тоо | 3 | 5 | Тайлант хугацаанд байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний дараах актыг боловсруулж батлуулсан:<br>1.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/322 дугаар тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”;<br>2.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/316 дугаар тушаалаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны архив, албан хэрэг хөтлөлтийн дотоод журам;<br>3.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/85 дугаар тушаалаар “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”;<br>4.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/193 дугаар тушаалаар “Гадаад албан томилолтын журам”; | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/153 дугаар тушаалаар "Ахмадын санг ажиллуулах журам". | |
| **Зорилт 2. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын захиргааны шийдвэр, бусад байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний хууль эрхзүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл дэмжлэгээр хангах** | | | | | | | |
| 2.1. | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төслийн эрх зүйн үндэслэлийг хянах | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Хууль зүйн зөрчилтэй шийдвэр гаргуулахаас урьдчилан сэргийлсэн байх | Үйл ажиллагаатай холбоотой сайдын 135, Төрийн нарийн бичгийн даргын 331, хүний нөөцтэй холбоотой сайдын 61, Төрийн нарийн бичгийн даргын 169 тушаалын эрх зүйн үндэслэл, найруулгыг хянаж засвар оруулсан. | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцсэн байна. | Үйл ажиллагаатай холбоотой сайдын 165, Төрийн нарийн бичгийн даргын 343, хүний нөөцтэй холбоотой сайдын 60, Төрийн нарийн бичгийн даргын 145 нийт 713 тушаалын эрх зүйн үндэслэл, найруулгыг тухай бүрд хянаж, шаардлагатай засварыг хийж удирдлагын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн ажилласан. | 100% |
| 2.2. | Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны | Байгууллагын үйл | Хууль зүйн зөрчилтэй гэрээ | | Гэрээ хэлэлцээр, санамж бичиг Монгол Улсын Үндсэн хууль, | Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан Үйлчилгээний | 100 |

112

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүрээнд бусад байгууллага, иргэнтэй байгуулах гэрээ хэлэлцээр, санамж бичгийн төслийг хянах | ажиллагааны зардал | байгуулахаас урьдчилан сэргийлсэн байх | | бусад хууль тогтоомжид нийцсэн байна. | 26, Ажил гүйцэтгэх 6, Түрээсийн 6, Худалдах худалдан авах 6, яамны үндсэн үйл ажиллагаатай холбоотой 6 гэрээ тус тус баталгаажсан. Гэрээний төсөл болон гэрээ дүгнэсэн акт түүнтэй холбогдох гэрээний хэрэгжилтийг тухай бүрд хянаж, найруулгын болон эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>Инновацын төсөлд грант олгох тухай 14 гэрээг хянаж, гэрээний бүртгэлд бүртгэж, дугаар олгосон байна. | |
| 2.3. | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний биелэлтийн мэдээг танилцуулах, удирдлагыг мэдээллээр хангах | Байгууллагын үйл ажиллагааны зардал | Гэрээний биелэлтийн тайлангийн тоо | 0 | 4 | Тус яамны "Гэрээ байгуулахад мөрдөх дотоод журам"-ын 7.3-т заасны дагуу гэрээг байгуулсан нэгжийн холбогдох албан тушаалтан болон гэрээний төсөл боловсруулан батлуулсан албан хаагчдаас 2025 оны 1 дүгээр улиралд байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайланг нэгтгэн авч нэгжийн даргаас Төрийн нарийн бичгийн даргын шуурхай хуралдаанд танилцуулсан. Мөн 2 дугаар улирлын гэрээний хэрэгжилтийн тайланг 6 дугаар сарын 30-ны өдөр, 3 дугаар улирлын гэрээний хэрэгжилтийн тайланг 10 дугаар сарын 10-ны өдөр тус тус нэгтгэн боловсруулж, танилцуулсан бна. | 100 |

**1.2. НЭМЭЛТ АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ**



113

|  | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|
| *1* | *2* | *3* | *4* | *5* |
| 1. | Ажлын хэсэгт ажиллах | Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрээр | 1.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/82 дугаар тушаалаар байгуулсан мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн хүсэлтийг магадлан шалгаж, зөвшөөрлийг олгох эсэх талаар зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн гишүүн<br>2.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/30 дугаар тушаалаар байгуулсан "Цахим шилжилтийг хийхэд шаардлагатай дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах" төслийн гэрээт ажлын явцын болон гүйцэтгэлийн тайланг баталгаажуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн ахлагч.<br>3.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/243 дугаар тушаалаар байгуулсан салбарын мэргэшсэн мэргэжилтнүүдийн практик мэдлэг мэдээллийг оюутнуудад заах боломжийг бүрдүүлж цагийн багш хөтөлбөр боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн гишүүн<br>4.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/259 дүгээр тушаалаар байгуулсан "Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт нөлөөллийн үнэлгээ хийх" ЦХИХХЯ/20250203053 дугаартай гэрээт ажлын тайлан, баримт материалыг хүлээн авах Ажлын хэсгийн гишүүн<br>5.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/264 дүгээр тушаалаар байгуулсан "Инновац, өндөр технологи, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын санг байгуулах судалгаа хийх, экосистемийн замын зураглал боловсруулах" ЦХИХХЯ/20250203101 дугаартай гэрээт ажлын тайлан, баримт материалыг хүлээн авах Ажлын хэсгийн гишүүн<br>6.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/279 дүгээр тушаалаар байгуулсан яамны хэмжээнд Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийн гишүүн<br>7.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/310 дугаар тушаалаар байгуулсан Салбарын хэмжээнд болон тус яамны хэмжээнд нууцлах төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт, салбарын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийн ахлагч | 100 |



114

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ зохион байгуулах | Сайдаас өгсөн чиглэлийн хүрээнд | Сайдын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын дагуу "Үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 2025.04.18-ны өдрийн А/59 тоот тушаалын төслийг боловсруулж, хариуцсан нэгжийн дарга нар болон харьяа байгууллагуудын удирдлагуудаас санал авч тушаалын төслийг боловсруулж батлуулсан. Мөн ТАЗ-руу 2, ТӨБЗГ-руу 4 албан бичгийг тус тус боловсруулж хүргүүлсэн.<br><br>ЦХИХХ-ны сайд Ц.Баатархүүгээс өгсөн чиглэлийн дагуу Цахим хөгжил, инновац харилцаа холбооны салбарт мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээний актад дүн шин шинжилгээ хийлээ. Харилцаа холбооны зохицуулах хорооноос батлагдсан 44 захиргааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийх Ажлын хэсгийг ахалсан.<br><br>Мөн ЦХИХХ-ны сайд Э.Батшугараас өгсөн үүрэг даалгаврын дагуу МҮБХ-руу албан бичиг төлөвлөж хүргүүлсэн. Уг албан бичгийн хүрээнд СПАЖЗ-ын сайдын тушаалаар Ажлын хэсэгт ажиллаж байна. | |
| 3 | Үнэлгээний хороонд ажиллах | Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрээр | 1.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулсан "Албан хаагчдын тоног төхөөрөмж, бараа худалдан авах" ЦХИХХЯ/20250202012 дугаартай төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга<br>2.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар байгуулсан "Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бий болгох" УЗ 2 төсөл 2.3.2.1 төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга<br>3.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/90 дүгээр тушаалаар байгуулсан "Хотын инновацын төв-хотын тодорхой нэг хэсгийг сонгон ухаалаг, инновацлаг төв гудамж байгуулах туршилтын төсөл эхлүүлэх" ЦХИХХЯ/20250103128 дугаартай төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга<br>4.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/95 дугаар тушаалаар байгуулсан "Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт нөлөөллийн үнэлгээ хийх" ЦХИХХЯ/20250203053 дугаартай төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга | 100 |



115

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 5.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/98 дугаар тушаалаар байгуулсан "Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах" ЦХИХХЯ/20250103038, "Дрон жолоодлогын сургалтын хөтөлбөр боловсруулах, шалгалт баталгаажуулалтын гарын авлага боловсруулах" ЦХИХХЯ/20250206111 дугаартай төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга<br>6.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/112 дугаар тушаалаар байгуулсан "Өндөр хөгжилтэй орнуудын гарааны бизнес, хөрөнгө оруулалт, өндөр технологи, инновацын талаарх шинэ мэдлэг, мэдээлэл, ноу-хау импортлох, нутагшуулах ажлыг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250103099, "Инновацлаг санааг хөгжүүлэх бүх насны иргэдэд зориулсан 10 цуврал бичлэг, нэвтрүүлэг, материал бүтээх" ЦХИХХЯ/20250203105 дугаартай төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга<br>7.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/113 дугаар тушаалаар байгуулсан "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсүүдэд, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарынхны дунд зөвлөгөөн зохион байгуулах" ЦХИХХЯ/20250103093, "Өгөгдлийн стратеги боловсруулах" ЦХИХХЯ/20250203066, "ICT экспо 2025 арга хэмжээг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250103113 дугаартай төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга<br>8.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/118 дугаар тушаалаар байгуулсан "Төрийн үйлчилгээний цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах" ЦХИХХЯ/20250103063 дугаартай төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга<br>9.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/136 дугаар тушаалаар байгуулсан "Дижитал эдийн засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250103059 дугаартай төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга<br>10.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/221 дүгээр тушаалаар байгуулсан "Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг | 100 |



116

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | сайжруулах дэд бүтцийг бий болгох" УЗ 2 төсөл 2.3.2.1 төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга<br>11.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/275 дугаар тушаалаар байгуулсан "Мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэгчдийн бүртгэлийн нэгдсэн платформ хөгжүүлэх" ЦХИХХЯ/20250203083 дугаартай төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга<br>12.Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/283 дугаар тушаалаар байгуулсан "Засгийн газрын архивын цахим систем хөгжүүлж, нэвтрүүлэх" УЗ 2 төсөл 2.1.6.2 төслийн тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хорооны дарга. | |
| 4 | Бусад байгууллагын Ажлын хэсэгт орж ажилласан байдал | Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрээр | 1. ХЗДХ-ийн Сайдын тушаалаар<br>- Онц байдлын тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн гишүүн<br>- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн гишүүн<br>- Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн гишүүн<br>2. ХББОС-ийн сайдын тушаалаар "Хаягжуулалтын тухай хууль"-ийн Ажлын хэсгийн гишүүн<br>3. ГБХН-ийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүн<br>- "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"<br>- "Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Зөвлөлийн ажиллах журам"<br>- "Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн"<br>4. Шадар сайд Т.Доржхандын тушаалаар байгуулсан<br>- "Хөрөнгө оруулалтын тухай хууль"<br>- Өрсөлдөөний тухай хууль | 100 |
| 5 | Нууц хамгаалан ажлын хүрээнд | ТНБД-ын тушаалаар | 1. Салбарын нууцын мэдээллийн жагсаалтыг шинэчлэн батлах саналыг боловсруулж ТЕГ-т хүргүүлсэн<br>2. Байгууллагын нууцын мэдээллийн жагсаалтыг шинэчлэн батлах саналыг боловсруулж ТЕГ-т хүргүүлсэн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 3. Бичиг хэргийн хүрээнд нийт 85 бичиг хүлээн авч 65 бичгийн хариуг хугацаанд хүргүүлсэн. | |
| 6 | Дайчилгааны төлөвлөгөө батлуулах ажлын хүрээнд | ТНБД-аас өгсөн чиглэлийн хүрээнд | 1. Яамны дайчилгааны төлөвлөгөөг боловсруулж 2025 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр сайдаар батлуулж БХЯ-нд хүргүүлсэн.<br>2. Салбарын дайчилгааны төлөвлөгөө батлуулах ажлын хэсгийг байгуулж, салбарын 10 байгууллагын нууцын ажилтад 2 удаагийн сургалтыг БХЯ-тай хамтран зохион байгуулсан. | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Удирдлагын академиас зохион байгуулах сургалтад хамрагдаж, мэргэшлээ дээшлүүлэх | Суралцсан кредит цаг | 0 | | Дотоод хэргийн их сургуульд "Хууль зүйн доктор"-ын зэрэг хамгаалахаар 3 дахь жилдээ суралцаж байна.<br>Удирдлагын академиас зохион байгуулсан "Эрхэлсэн түшмэлийн багц сургалт-д суралцаж гэрчилгээгээ авсан болно. | 01-12 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2.<br>Албан тушаалын тодорхойлолтод заасан чиглэлээр зохион байгуулж байгаа сургалтад хамрагдах | Хамрагдсан сургалтын тоо | 0 | 1 | ХЗДХЯ-аас зохион байгуулсан "Захиргааны хэм хэмжээний акт боловсруулах анхаарах асуудал-сургалт хэлэлцүүлэг"<br>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албаны тухай хуулийн, Төрийн албан ёсны ёс зүйн хуулийн болон шинэтгэлтэй холбоотой сургалт, хэлэлцүүлэг"<br>НҮБ-ын хүүхдийн сангаас зохион байгуулсан "Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах" | 01-12 | 100 |



118

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ............................ /Б.МЯГМАРНАРАН/ ............................ *(огноо)*

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* **Нэгжийн дарга**

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ............................ /С.ЦАГААНХҮҮ/ 2025.12.19 *(огноо)*

*Тайлагнасан:* **Нэгжийн дарга**

ХЭЛТСИЙН ДАРГА ............................ /Л.НЯМДОРЖ/ ............................ *(огноо)*



119